



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн ес дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж
Утас: 77721628

Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2026.02.24 № 54

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН ЕСДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.АРИУНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн Ес дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 677,401.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 719,443.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,784,408.43	60,755,531.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	60,659,070.43	18,617,069.11
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	60,659,070.43	18,617,069.11
3121	Төгрөг	60,659,070.43	18,617,069.11
31211	Төрийн сангийн харилцах	60,659,070.43	18,617,069.11
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	35,125,338.00	42,138,462.00
354	Хангамжийн материал	35,125,338.00	42,138,462.00
3542	Аж ахуйн материал	33,625,338.00	35,822,422.00
3545	Барилгын засварын материал	1,500,000.00	1,500,000.00
3547	Бусад хангамжийн материал	-	4,816,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	306,873,655.18	298,179,568.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	306,873,655.18	298,179,568.40
392	Биет хөрөнгө	284,113,030.18	275,666,443.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	307,689,002.00	307,689,002.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,211,517.40)	(70,821,483.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,148,736.00	65,982,486.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,699,808.70)	(29,452,061.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,471,418.00	4,099,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,454,799.72)	(2,000,620.06)
39217	Ном	170,000.00	170,000.00
393	Биет бус хөрөнгө	22,760,625.00	22,513,125.00
39301	Програм хангамж	1,537,500.00	1,537,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,021,875.00)	(1,269,375.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,245,000.00	22,245,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	402,658,063.61	358,935,099.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	402,658,063.61	358,935,099.51
51	Засгийн газрын хувь оролцоо	402,658,063.61	358,935,099.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	22,245,000.00	22,245,000.00
51101	Өмч: - төрийн	22,245,000.00	22,245,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	380,413,063.61	336,690,099.51
5121	Өмнөх үеийн үр дүн	380,413,063.61	380,413,063.61
5122	Тайлант үеийн үр дүн	-	(43,722,964.10)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	402,658,063.61	358,935,099.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	659,633,150.0	735,839,870.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,425,650.00	32,235,770.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,425,650.00	32,235,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	22,285,650.00	13,176,880.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		18,883,890.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,207,500.00	703,604,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	576,165,600.00	641,991,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	576,165,600.00	641,991,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,041,900.00	61,612,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,041,900.00	61,612,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	671,695,875.43	779,562,834.10

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн есдүгээр цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,695,875.43	779,562,834.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,477,094.38	749,726,797.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,919,016.00	545,147,702.32
210101	Үндсэн цалин	324,440,571.00	343,305,866.68
210102	Нэмэгдэл	97,017,640.00	58,012,435.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,330,000.00
210104	Урамшуулал	32,460,805.00	32,499,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,847,834.00	62,600,100.00
210201	Тэтгэврийн даатгал	39,389,254.40	42,568,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,633,984.40	5,008,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,316,701.45	2,504,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,239,818.95	2,504,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,268,074.80	10,016,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,554,118.95	35,235,163.32
210301	Гэрэл, цахилгаан	24,697,660.00	30,773,002.00
210303	Цэвэр, бохир ус	3,856,458.95	4,462,161.32
2104	Хангамж, бараа материалын зардал	6,394,961.00	14,067,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		14,067,850.00
210408	Бараа материал актальсны зардал	6,394,961.00	
2105	Нормативт зардал	48,108,955.00	50,657,619.00
210502	Хоол, хүнс	48,108,955.00	50,657,619.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,300,000.00	
210604	Урсгал засвар	6,300,000.00	
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		1,448,600.00	2,952,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,448,600.00	2,952,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,903,609.43	39,065,662.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,990,600.00	11,182,996.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,836,900.00	4,514,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,076,109.43	23,367,966.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,218,781.05	29,836,036.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,531,000.00	3,458,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,531,000.00	3,458,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,687,781.05	26,377,736.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,687,781.05	26,377,736.68
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(12,062,725.43)	(43,722,964.10)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,062,725.43)	(43,722,964.10)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	637,347,500.00	703,779,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,000.00	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,000.00	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,207,500.00	703,604,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	576,165,600.00	641,991,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	576,165,600.00	641,991,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,041,900.00	61,612,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,041,900.00	61,612,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	656,234,505.00	744,324,101.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	656,234,505.00	744,324,101.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,015,723.95	714,488,064.64

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн есдүгээр цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,919,016.00	545,147,702.32
210101	Үндсэн цалин	318,521,445.00	343,305,866.68
210102	Нэмэгдэл	102,105,881.00	158,012,435.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,330,000.00
210104	Урамшуулал	33,291,690.00	32,499,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,847,834.00	62,600,100.00
210201	Тэтгэврийн даатгал	39,389,300.00	42,568,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,634,000.00	5,008,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,316,658.25	2,504,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,239,775.75	2,504,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,268,100.00	10,016,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,554,118.95	35,235,163.32
210301	Гэрэл, цахилгаан	24,697,660.00	30,773,002.00
210303	Цэвэр, бохир ус	3,856,458.95	4,462,161.32
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	48,108,955.00	50,657,619.00
210502	Хоол, хүнс	48,108,955.00	50,657,619.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,800,000.00	-
210604	Урсгал засвар	7,800,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,887,600.00	2,952,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,887,600.00	2,952,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,898,200.00	17,894,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,403,100.00	12,425,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,495,100.00	5,469,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,218,781.05	29,836,036.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,531,000.00	3,458,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,531,000.00	3,458,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,687,781.05	26,377,736.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,687,781.05	26,377,736.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(18,887,005.00)	(40,545,001.32)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		1,497,000.00
	Дотоод эх үүсвэрээр		-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,497,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(1,497,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,887,005.00)	(42,042,001.32)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	79,546,075.43	60,659,070.43
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,659,070.43	18,617,069.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	22,245,000.00	392,475,789.04	414,720,789.04
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
4-08	Тайлант үеийн үр дүн	-	(12,062,725.43)	(12,062,725.43)
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	22,245,000.00	380,413,063.61	402,658,063.61
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,245,000.00	380,413,063.61	402,658,063.61
4-08	Тайлант үеийн үр дүн	-	(43,722,964.10)	(43,722,964.10)
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	22,245,000.00	336,690,099.51	358,935,099.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	759,277,600.00	719,443,364.64	39,834,235.36	94.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759,277,600.00	719,443,364.64	39,834,235.36	94.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	755,819,300.00	715,985,064.64	39,834,235.36	94.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,459,300.00	545,147,702.32	1,311,597.68	99.76
210101	Үндсэн цалин	362,470,000.00	343,305,866.68	19,164,133.32	94.71
210102	Нэмэгдэл	159,658,700.00	158,012,435.64	1,646,264.36	98.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт		11,330,000.00	(11,330,000.00)	
210104	Урамшуулал	24,330,600.00	32,499,400.00	(8,168,800.00)	133.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,951,100.00	62,600,100.00	5,351,000.00	92.13
210201	Тэтгэврийн даатгал	46,092,700.00	42,568,000.00	3,524,700.00	92.35
210202	Тэтгэмжийн даатгал	5,464,600.00	5,008,000.00	456,600.00	91.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,732,300.00	2,504,000.00	228,300.00	91.64
210204	Ажилгүйдлийн даатгал	2,732,300.00	2,504,000.00	228,300.00	91.64
210205	Эрүүл мэндийн даатгал	10,929,200.00	10,016,100.00	913,100.00	91.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,612,900.00	35,235,163.32	26,377,736.68	57.19
210301	Гэрэл, цахилгаан	35,469,800.00	30,773,002.00	4,696,798.00	86.76
210303	Цэвэр, бохир ус	26,143,100.00	4,462,161.32	21,680,938.68	17.07
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	57,334,100.00	50,657,619.00	6,676,481.00	88.36
210502	Хоол, хүнс	57,334,100.00	50,657,619.00	6,676,481.00	88.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		-	-	-
2107	Томилолт, зочны зардал		-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,960,500.00	2,952,700.00	7,800.00	99.74
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,960,500.00	2,952,700.00	7,800.00	99.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,501,400.00	19,391,780.00	(65,380.00)	100.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,031,700.00	13,922,080.00	(65,380.00)	100.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,469,700.00	5,469,700.00		100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,458,300.00	3,458,300.00		100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,458,300.00	3,458,300.00		100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,458,300.00	3,458,300.00		100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		-	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-	-
	Дотоод эх үүсвэрээр		-	-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	759,277,600.00	677,401,363.32	81,876,236.68	89.22
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	642,538,100.00	641,991,200.00	546,900.00	99.91
131001	Улсын төсвөөс санхүүжих	642,538,100.00	641,991,200.00	546,900.00	99.91
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,612,900.00	35,235,163.32	26,377,736.68	57.19
132001	Орон нутгийн төсвөөс	61,612,900.00	35,235,163.32	26,377,736.68	57.19
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	55,126,600.00	175,000.00	54,951,600.00	0.32

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	175,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	54,951,600.00	-	54,951,600.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,659,070.43	60,659,070.43	-	100.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,659,070.43	18,617,069.11	42,042,001.32	30.69
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1	-	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100
6	Удирдах ажилтан	2	2	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	9	9	-	100
8	Үйлчлэх ажилтан	12	12	-	100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 4,093.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3,494.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 599.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 4,093.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 8,607.2 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.04-ний өдрийн Б/30 дугаар тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онцтүвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 345.8 мянган төгрөг суутган 3,112.5 мянган төгрөгийг 15 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 830.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”: 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2 Зөвлөмж

3.2.1 Үндсэн хөрөнгийн алдаатай тайлагнал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдэл, орлого, зарлагыг харгалзах ерөнхий дэвтрийн дансны үлдэгдэл, дебет, кредиттэй тулгахад Машин тоног төхөөрөмж-компьютер дансны эхний үлдэгдлийн анхны өртөг 1,134.8 мянган төгрөгөөр, Машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 599.0 мянган төгрөгөөр, нийт 535.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь мөн тайлант үеийн эцсийн үлдэгдэлд зөрүүтэй хэвээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх зарчмыг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх зарчмыг хангаж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Албан шаардлага					
			Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0	1	2,664.0				
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	830.0	1	830.0				
Үндсэн хөрөнгийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй байна.	1	599.0			1	599.0		
Дүн	5	4,093.00	2	3,494.0	1	599.0	-	-